

БАТЛАВ.
ЗАХИАЛАГЧ

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ ТӨРИЙН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Я.АМАРЖАРГАЛ



ШИНЭ ТӨРЛИЙН КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (КОВИД-19)-ЫН ҮЕД
ШААРДЛАГАТАЙ ЛАБОРАТОРИЙН УРВАЛЖ,
ОНОШЛУУР НИЙЛҮҮЛЭХ ГЭРЭЭ

Дугаар № 411

Улаанбаатар хот

Нэг талаас Эрүүл мэндийн яам (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас ПРОЛИАНС ХХК (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож 2020 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

- Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
- Эм худалдан авах гэрээг (цаашид “бараа” гэх) 210,000,000 (хоёр зуун арван сая) төгрөгөөр (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

Хүснэгт 1. Нийлүүлэх бараа

Барааны нэр, төрөл	Багцийн дугаар	Үйлдвэрлэгч, Улс	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгж үнэ /НӨАТ орсон/	Нийт үнэ
SARS-Cov-2 цомог оношлуур	Багц-5 Коронавирусийн SARS-CoV-2 цомог оношлуур (ПГУ-ын цомог оношлуур)	Wuhan Easydiagnosis Biomedicine Co., Ltd, БНХАУ	ширхэг	200	1,050,000	210,000,000

- Захиалагч нь барааны нийлүүлэлтийг 210,000,000 (хоёр зуун арван сая) төгрөгийг Улсын төсөв хөрөнгөөр санхүүжүүлнэ.
- Нийлүүлэгч нь нэг нэр төрлийн барааг 2020 оны 11 дугаар сарын 12-ны өдрөөс 2020 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.

3. Дор дурдсан бичиг баримт нь гэрээний хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
 Бусад шаардлагатай баримт бичиг¹;
 Тендер ба үнийн хуваарь;
 Гэрээний тусгай нөхцөл;
 Гэрээний ерөнхий нөхцөл;
 Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
 Санхүүжилтийн хуваарь.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвэл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

4. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хариуцлагыг хүлээж байна.
5. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг хариуцлага хүлээж байна.
6. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

Хүснэгт 2. Санхүүжилтийн хуваарь

Д/Д	Барааны нэр, төрөл	Багцийн дугаар	Урьдчилгаа /төгрөг/	Гүйцэтгэл /төгрөг/
1	SARS-CoV-2 цомог оношлуур	Багц-5 Коронавирусийн SARS-CoV-2 цомог оношлуур (ПГУ-ын цомог оношлуур)	105,000,000	105,105,000

ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

Чэр томъёо Энэ гэрээнд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

- (а) “Гэрээ” гэж захиалагч, нийлүүлэгчийн хооронд тохиролцсон бараа нийлүүлэх гэрээг хэлнэ. Гэрээ нь талуудын гарын үсэг зурсан гэрээний маягт, түүнийг дагалдах хавсралт, бусад баримт бичгээс бүрдэнэ.
- (б) “Гэрээний үнэ” гэж гэрээний дагуу гэрээний үүргээ бүрэн биелүүлж хангалттай гүйцэтгэсний дагуу нийлүүлэгчид төлөх үнийг хэлнэ.
- (в) “Хоног” гэж хуанлийн хоногийг хэлнэ.
- (г) “Хүчинтэй болох хугацаа” Гэрээ хүчин төгөлдөр болох өдөр.
- (д) “Ашиглагч” Барааг хэрэглэх ГТН-д заагдсан эцсийн хэрэглэгчийг хэлнэ.
- (е) “ГЕН” Гэрээний Ерөнхий Нөхцөл.
- (ж) “Бараа” Гэрээний дагуу Захиалагчид нийлүүлэх бүх эм, эмнэлгийн хэрэгсэлийг хэлнэ.
- (з) “Захиалагч” гэж барааг худалдан авч буй гэрээний тусгай нөхцөлд нэрлэсэн байгууллагыг хэлнэ.
- (и) “Бүртгэлийн гэрчилгээ” хуулийн дагуу Монгол улсад бүртгэгдсэн гэрээгээр нийлүүлэх барааны гэрчилгээ.
- (к) “ГТН” Гэрээний Тусгай Нөхцөл.
- (л) “Үйлчилгээ” гэж тээвэрлэлт, даатгал болон бусад дагалдах үйлчилгээ, техникийн туслалцаа, сургалт зэрэг гэрээний дагуу нийлүүлэгчийн хариуцах үйлчилгээг хэлнэ.
- (м) “Байршил” ГТН-д заасан барааг хүргэх байршил.
- (н) “Нийлүүлэгч” ГТН-д заагдсан бараа болон үйлчилгээг гүйцэтгэх этгээдийг хэлнэ.

ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

1. Тодорхойлолт (ГЕН-ийн Зүйл 1)

ГЕН 1.1 (и)	Захиалагч нь: Эрүүл мэндийн яам
ГЕН 1.1 (о)	Нийлүүлэгч нь: ПРОЛИАНС ХХК
ГЕН 1.1 (н)	Байршил: Улаанбаатар 14210, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Олимпийн гудамж 15/2, Мид таун оффис, 3-р давхар. Утас: 976-11330276
ГЕН 1.1 (е)	Ашиглагч байгууллага: ХӨСҮТ, аймаг, нийслэлийн ЭМГ, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг тусгай мэргэжлийн төв, бусад байгууллага

2. Үйлчлэх хүрээ (ГЕН-ийн Зүйл 2)

ГЕН 2	ГЕН-ийн 2-т хамаарах тусгай нөхцөл байхгүй
-------	--

3. Барааны гарал үүслийн улс (ГЕН-ийн Зүйл 3)

ГЕН 3	ГЕН-ийн 2-т хамаарах тусгай нөхцөл байхгүй
-------	--

4. Стандарт (ГЕН-ийн Зүйл 4)

ГЕН 4	Тендерийн баримт бичгийн техникийн тодорхойлолтод заасан стандарт болон бусад шаардлагууд
-------	---

5. Гэрээний баримт бичгийг хэрэглэх (ГЕН-ийн Зүйл 5)

ГЕН 5	ГЕН-ийн 5-т хамаарах тусгай нөхцөл байхгүй
-------	--

6. Барааны бүртгэлийн гэрчилгээ (ГЕН-ийн Зүйл 6)

ГЕН 6.1	Монгол улсад бүртгэгдсэнийг нотлох холбогдох бүртгэлийн болон болон бусад гэрчилгээ
---------	---

7. Оюуны өмчийн эрх (ГЕН-ийн Зүйл 7)

ГЕН 7	ГЕН-ийн 7-д хамаарах тусгай нөхцөл байхгүй
-------	--

8. Гүйцэтгэлийн баталгаа (ГЕН-ийн Зүйл 8)

ГЕН 8.1	Гэрээний үнийн дүнгийн 5% -аар гүйцэтгэлийн баталгаа ирүүлнэ.
ГЕН 8.4	Энэ баталгаа нь ажил дууссан тухай мэдэгдэл гаргаснаас хойш 28 хоногийн хугацаанд хүчинтэй байна.

9. Шалгах болон турших (ГЕН-ийн Зүйл 9)

ГЕН 9.1	ХӨСҮТ-ийн холбогдох мэргэжилтнүүд шалгаж, туршина.
---------	--

10. Баглаа боодол (ГЕН-ийн Зүйл 10)

ГЕН 10.2	Тендерийн баримт бичгийн техникийн тодорхойлолтод заасан стандарт болон бусад шаардлагууд
----------	---

11. Барааны нийлүүлэлт болон баримт бичгийн бүрдүүлэлт


ГЕН 11.1	(CIP нөхцөл) Монгол улсын гаднаас нийлүүлэх барааны хувьд:
----------	---

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:


Ул мэндийн яамны Эм, үйлдвэрлэл,
тологийн газрын дарга

 Н.Гэрэлт-Од

Ул мэндийн яамны Эдийн засаг, санхүү
энгэ оруулалтын газрын дарга

 Д.Нарантуяа


Ул мэндийн яамны ЭМСЭЗБХГ,
түүгийн хэлтэсийн дарга

 Т.Хонгорзул

Ул мэндийн яамны Аппратын тооцооны
лан бодогч

 Э.Эрдэнэцэцэг

Ул мэндийн яамны ТЗУГ-ын Захиргаа,
түйн хэлтэсийн мэргэжилтэн

 Д.Мөнхцэцэг

Ул мэндийн яамны Параклиник,
баторийн

ал хариуцсан мэргэжилтэн

 М.Долгион

*Сүр-шии Нэгдсн лабораторийн
Улаанбаатар хот Сүхбаатар
г Олимпийн гудамж 2, Засгийн газрын VIII*

263695

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Эмнэлгийн Тоног Төхөөрөмжийн
Албаны захирал



Х.Армия - г

Ерөнхий нягтлан бодогч

 Н.Сэлэнгэ

Хаяг:

Улаанбаатар 14210,
Сүхбаатар дүүрэг,
1-р хороо, Олимпийн гудамж 15/2,
Мид таун оффис, 3-р давхар.
Утас: 976-11330276

Харилцах банк:

Худалдаа Хөгжлийн Банк

Дансны дугаар: **499 109 431**